

**Диспетчерийн зохицуулалтын 2010 оны
1 дүгээр сарын ажлын тайлан**

Нэг. Диспетчерийн зохицуулалт

ДҮТ ХХК нь Эрчим хүчний хууль, ЭХЗГ-ын тогтоол, шийдвэр, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд Диспетчерийн шуурхай зохицуулалтыг цаг тухай бүрд нь хийж нэгдсэн сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллаа. 1-р сард хүйтний эрч эрс чангарч, шөнөдөө -40 хэм хүрч байсан нь Багануурын нүүрсний уурхайн хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учруулсантай уялдуулан 8-10, 13-19-ний өдрүүдэд ДЦС-уудыг нүүрс хэмнэлтийн горимд шилжүүлэн цахилгаан ачааллыг нь бууруулан төлөвлөж, хэрэглээний өсөлтийг импортоор хангах горимын төлөвлөлт, зохицуулалтыг хийж ажилласан.

ЭБЭХЯ

- Цахилгаан түгээлтийн мэдээг сараар болон өссөн дүнгээр, өнгөрсөн жилтэй харьцуулан гаргаж хүргүүлэв.
- Яамны интернэтийн хурдыг нэмэх төхөөрөмж суурьлуулж тохируулж өгөв.

ЭХГ

- Хямралын үед ажиллах ажлын төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж хүргүүлсэн.

ЭХЗГ

- ТБНС-ний 2010 оны ЦЭХ, ДЦС-уудын үйлдвэрлэлтийн төлөвлөгөөг тооцоолж хүргүүлсэн.

I сард станцуудад нийлүүлсэн нүүрс, нүүрс, мазутын нөөц

Станц	Нүүрс (тонн)						Мазутын үлдэгдэл II/01-ны байдлаар (тн)
	Графикаар нийлүүлэх	Нийлүүлсэн	Дутуу нийлүүлэлт (зөрүү)	I сард түлсэн	II/01-ны байдлаар Үлдэгдэл	нөөц (хоног)	
ДЦС-2	23000	24621	1621	23470	7621	10	184,2
ДЦС-3	55000	45803	-9197	51679	29416	6	481,3
ДЦС-4	305000	328482	23482	300802	82505	9	304
ДДЦС	151125	155967	4842	153673	15734	10	97
ЭДЦС	40000	37889	-2111	39348	9700	7	40,8

Жич: Цаг агаарын байдал хүндэрч хүчтэй салхи шуурга, хэт хүйтрэлээс шалтгаалж Төвийн бүсийн ДЦС-уудыг нүүрсээр хангадаг Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудын хоногт гаргах нүүрсний хэмжээ буурч улмаар ДЦС-уудын нүүрсний нөөц багасах нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан ДҮТ ХХК-иас станцуудын нүүрсний нөөцийг тодорхой хэмжээнд барих зорилгоор нүүрс хэмнэлтийн горимд 2010 оны 1 дүгээр сарын 8-10-нд, 12-19-ны хооронд ажилласан хэдийч нөөц төдийлөн нэмэгдэхгүй 2 дугаар сарын 1-ний байдлаар станцууд **6-10** хоногийн нүүрсний нөөцтэй байгааг онцгой анхаарч нөөцийг шаардлагатай хэмжээнд хүргэж нэмэгдүүлэх арга хэмжээг цаашид үргэлжлүүлэн авах хэрэгтэй байна.


**Хоёр. Нэгдсэн сүлжээний ЦЭХ-ний нийт хэрэглээний төлөвлөлт, биелэлт
(мян.кВт.цаг)**

Нэгдсэн сүлжээ	2010 оны I сар			2009 оны I сарын гүйцэтгэл	2009, 2010 оны I сарын зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү		
Хэрэглээ	404,951.732	426,999.823	22,048.1	399,639.3	27,360.558
Боловсруулалт	394,951.732	405,857.174	10,905.4	391,301.176	14,556.0
Түгээлт	323,793.332	333,314.325	9,521.0	321,759.766	11,554.6
Импорт	10,000.000	21,142.649	11,142.6	8,338.089	12,804.6
Экспорт	1,900.000	1,332.166	-567.8	2,061.277	-729.1


Нийт хэрэглээ: 2010 оны 1 дүгээр сард 426 999,8 мян.кВт.ц хүрсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 5,4% буюу 22 048,1 мян.кВт.ц, өнгөрсөн оноос 6,8% буюу 27 360,6 мян.кВт.ц-ийн тус тус өсөлттэй байна.

Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулбал 1-р сард хүйтний эрч эрс чангарч, олон жилийн дунджаас 1,2 хэмээр хүйтэн байсантай холбоотой хоногийн хэрэглээ дунджаар 0,8-1,0 сая кВт.ц-аар нэмэгдсэн байна.

1-р сарын хоногийн хэрэглээ, мян.кВт.ц



1-р сарын оргил ачаалал 711 МВт, бага ачаалал 455 МВт байсан. Сүүлийн жилүүдийн 1 дугаар сарын их, бага ачааллын хэмжээг графикаар харуулав. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад энэ сарын их ачаалал 47 МВт-аар, бага ачаалал 30 МВт-аар тус тус дээгүүр байсан байна.



Хэрэглээ түгээлтээр: Хэрэглэгчдэд нийт 354,5 сая кВт.ц эрчим хүч түгээсэн нь төлөвлөгөөнөөс 6,2% буюу 20,7 сая кВт.ц, өнгөрсөн оны мөн үеэс 7,4% буюу 24,4 сая кВт.ц-ийн тус тус өсөлттэй байна.

Гурав. ДЦС-уудын цахилгаан эрчим хүчний зохицуулалт

Станц	Боловсруулалт (мян.кВт.ц)			Дотоод хэрэгцээ (%)		НХА-ийн түгээлт (мян.кВт.ц)		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвл.	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
ДЦС-2	13,510.000	13,444.356	99.5%	18.6%	18.0%	10,881.000	10,928.049	100.4%
ДЦС-3	77,519.400	77,439.100	99.9%	22.6%	24.5%	59,242.500	57,951.650	97.8%
ДЦС-4	255,849.532	268,174.240	104.8%	16.0%	15.4%	214,412.986	226,823.866	105.8%
ДДЦС	29,500.000	28,356.552	96.1%	21.0%	21.8%	23,249.484	22,053.621	94.9%
ЭДЦС	18,572.800	18,442.926	99.3%	21.2%	20.7%	14,497.400	14,439.684	99.6%
Систем	394,951.732	405,857.174	102.8%	18.0%	17.9%	322,283.370	332,196.870	103.1%

1 дүгээр сард дотоодын үйлдвэрлэлтээр 405,9 сая кВт.ц эрчим хүч үйлдвэрлэсэн нь төлөвлөгөөнөөс 2,8% буюу 10,9 сая кВт.ц, өнгөрсөн оны мөн үеэс 3,7% буюу 14,6 сая кВт.ц-ийн тус тус өсөлттэй байна.

Дотоодын түгээлтээр 333,3 сая кВт.ц эрчим хүчийг түгээсэн нь батлагдсан төлөвлөгөөнөөс 2,9% буюу 9,5 сая кВт.ц, өнгөрсөн оны мөн үеэс 3,1% буюу 9,9 сая кВт.ц-ийн тус тус өсөлттэй байсан байна.

Энэ шалтгаанаар импортоор 21 142,6 мян.кВт.ц ЦЭХ-ийг авсан нь төлөвлөснөөс 11 142,6 мян.кВт.ц, өнгөрсөн оны мөн үеэс 12 804,6 мян.кВт.ц-ийг илүү авсан байна. Мөн ДЦС-3, ДДЦС-ууд НХА-д түгээх ЦЭХ-ний хэмжээ нь төлөвлөснөөс 1,2-1,3 сая кВт-цаар тасрах болсон байна. Сарын сүүлийн өдрүүдэд эдгээр станцуудын цахилгаан ачааллыг нэмэгдүүлэх горимын санал тавьсан боловч ДЦС-3, ДДЦС-уудын нүүрсний нөөц бага, хүйтний эрч сулраагүй шалтгаанаар тасалдлыг бууруулах боломжгүй байсан.

Нийт 1,3 сая кВт.ц. эрчим хүчийг экспортонд өгсөн нь төлөвлөгөөнөөс 0,6 сая кВт.ц-аар буюу 29,9%-иар хэмнэсэн байна.

Системийн дүнгээр ДЦС-ууд цахилгааны диспетчерийн графикайг 100,5%-иар биелүүлсэн байна. Дотоод хэрэгцээ төлөвлөгөөнөөс биетээр 1,4 сая кВт.ц-аар хэтэрсэн боловч 0,1%-иар хэмнэгдсэн байна.

Дөрөв. Цахилгаан эрчим хүчний худалдаа, баланс


ДЦС-тай тохирсон диспетчерийн графикайг биелэлт болон дамжуулах, түгээх ТЗЭ-ийн хамтарсан актыг үндэслэн цахилгаан эрчим хүчний нэгдсэн балансыг гаргав.

Нэгдсэн сүлжээний хэмжээгээр 2010 оны 1-р сард 354456.97 мян.кВт.ц эрчим хүчний хэрэглээ гарсан нь төлөвлөгөөтэй харьцуулахад 20663.64 мян.кВт.ц буюу 6.19% -иар, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7,38 % буюу 24359,12 мян.кВт.ц-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тайлант сард гаднах агаарын хэм өнгөрсөн оны мөн үеэс 3,2 хэмээр, олон жилийн дунджаас 1,2 хэмээр илүү хүйтэрсэн нь цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлт гарахад нөлөөлсөн байна.



Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	захиалга /2010 оны I сар/	гүйцэтгэл /2010 оны I сар/	зөрүү	%	гүйцэтгэл /2009 оны I сар/	зөрүү	%
Системийн хэрэглээ /түгээлтээр/	333 793,33	354 456,97	20 663,64	6,19%	330 097,86	24 359,12	7,38%
Станцын өөрийн түгээлт	1 509,96	1 117,46	-392,51	25,99%	1 503,71	386,25	25,69%
ТБЦДС ХК -ийн ХАЦ	332 283,37	353 339,52	21 056,15	6,34%	328 594,15	24 745,37	7,53%
техник алдагдал	9 763,57	9 466,03	-297,54	-3,05%	9 127,06	338,97	3,71%
дотоод хэрэгцээ	2 454,85	2 236,28	-218,57	-8,90%	2 445,32	-209,04	-8,55%
110-220 кВ -ын сүлжээний нийт алдагдал	12 218,42	11 702,31	-516,11	-4,22%	11 572,38	129,93	1,12%
%	3,68%	3,31%			3,52%		
экспорт	1 900,00	1 332,17	- 567,83	-29,9%	2 061,28	- 729,11	-35,4%
ТЗЭ -ийн худалдаж авсан ЦЭХ	320 064,95	341 637,21	21 572,26	6,74%	317 021,77	24 615,44	7,76%
УБЦТС ХК	166 621,34	176 644,06	10 022,71	6,02%	162 020,81	14 623,25	9,03%
Нолго	380,00	510,62	130,62	34,37%	379,94	130,68	34,39%
ДСЦТС ХК	33 763,30	41 228,61	7 465,31	22,11%	36 679,60	4 549,01	12,40%
ЭБЦТС ХК	84 621,00	84 266,58	-354,42	-0,42%	83 017,80	1 248,78	1,50%
Хөвсгөл	2 300,00	2 414,38	114,38	4,97%	2 050,82	363,56	17,73%
Баянхонгор	1 570,00	2 097,00	527,00	33,57%	2 023,56	73,44	3,63%
Эрдэнэт Амьдрал	2 000,00	1 968,16	-31,84	-1,59%	1 623,84	344,32	21,20%
БНЗӨБЦТС ХК	21 017,40	24 722,86	3 705,46	17,63%	21 411,53	3 311,33	15,47%
Төмөр зам	4 413,50	4 565,92	152,42	3,45%	4 452,63	113,30	2,54%
Эрчим сүлжээ ХХК	1 478,41	1 886,84	408,43	27,63%	1 299,96	586,88	45,15%


ТБЦДС ХК 353339,52 мян кВт.ц эрчим хүчийг худалдан авсан нь төлөвлөгөөтэй харьцуулахад 6,34% буюу 21056,15 мян.кВт.ц-аар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7,53 % буюу 24745,37 мян кВт.ц-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Дамжуулах сүлжээний алдагдал гүйцэтгэлээр 11702,31 мян.кВт.ц болсон нь төлөвлөсөн хэмжээнээс 516,11 мян.кВт.ц-аар буурч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 129,93 мян. кВт. ц-аар өссөн үзүүлэлттэй байна.



Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хэрэглээний төлөвлөгөө болон гүйцэтгэлийн зөрүү дараахи байдалтай байна. Үүнд:

- УБЦТС ХК-д төлөвлөгөөтэй харьцуулснаар 10022,71 мян.кВт.ц буюу 6,02%-ийн, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 14623,25 мян.кВт.ц буюу 9,03%-ийн өсөлт гарсан байна. Тайлант хугацаанд гарсан хэрэглээний өсөлтөнд гаднах агаарын хүйтрэлт нөлөөлсөн болно.

- ДСЦТС ХК-д төлөвлөгөөтэй харьцуулахад 7465,31 мян.кВт.ц буюу 22,11% -ийн, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 4549,01 мян.кВт.ц буюу 12,40% -ийн хэрэглээний өсөлт гарсан нь томоохон хэрэглэгч болох Хөтөл ЦШ ХК, Бороо гоульд ХХК, Дархан төмөрлөг ХХК –ууд захиалгаасаа нэмж авсан, гаднах агаарын хүйтрэлтээс шалтгаалж ахуйн хэрэглээний цахилгаан эрчим хүч нэмэгдсэн нь хэрэглээний өсөлтөнд нөлөөлжээ.
- ЭБЦТС ХК-д төлөвлөгөөтэй харьцуулахад 354,42 мян.кВт.ц буюу 0,42% -ийн хэрэглээний бууралт гарсан нь Эрдэнэт үйлдвэр ХХК нь захиалсан эрчим хүчнээсээ 2,5%-ийн дутуу цахилгаан эрчим хүч хэрэглэсэнтэй холбоотой байна. Харин өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 1248,78 мян.кВт.ц буюу 1,50%-ийн хэрэглээний өсөлт гарсан нь гаднах агаарын хүйтрэлтээс шалтгаалан гарсан ахуйн хэрэглэгч дээр гарчээ.
- БНЗӨБЦТС ХК-д төлөвлөгөөтэй харьцуулахад 3705,46 мян.кВт.ц буюу 17,63% -ийн, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 3311,33 мян.кВт.ц буюу 15,47%-ийн хэрэглээний өсөлт тус тус гарсан нь гаднах агаарын хүйтрэлтийн улмаас ахуйн хэрэглээнээс гадна Бор-Өндөрийн ГОК, Шивээ-Овоо, Дон Шейн, Багануурын уурхай, Багануурын ДС зэрэг томоохон хэрэглэгчид захиалгаасаа илүү эрчим хүч хэрэглэсэнтэй холбоотой.



2010 оны 1-р сард ДСЦТС ХК-ийн Үйлдвэр дэд станцаас ячейка №25,26 төлбөрийн асуудлаар, Мандалговиос Луус 35 кВ ЦДАШ-ын С фазын утас тасарсан, болон газардлага гарсан, Ерөө 110/10кВ дэд станцын трансформатор гэмтсэн, УБЦТС ХК -ийн Хайлааст дэд станцад ачаалал шилжүүлэх үед ВТ залгагдахгүй удсан, Дулаанхан 110/10 кВ –ын дэд станцын трансформатор 1 -д засвар орсон, Булган - Мөрөн 110 кВ –ын ЦДАШ –д гэмтэл гарсан, Сансар 110кВ ЦДАШ –ын тулгуур №220 -д утас сэргээсэн, Орхон 110/10 кВ дэд станц захиалгаар, Цэцэрлэг 110кВ –ын ЦДАШ-д гэмтэл гарсан зэрэг шалтгааны улмаас 12 удаагийн үйлдлээр 283,30 мян кВт.ц эрчим хүчийг дутуу түгээсэн байна.



Тав. ДЦС-уудын дулааны эрчим хүчний зохицуулалт

2010 оны 1-р сард системийн хэмжээгээр 1028,5945 мян Гкал дулаан үйлдвэрлэн 995,9115 мян Гкал дулааныг хэрэглэгчдэд түгээж ДҮТ-ийн зохицуулсан төлөвлөгөөг 100.0%-иар биелүүлэн ажиллав. Системийн дулаан түгээлт ҮСТ-нөөс 87,39 мян Гкал буюу 9.6%-иар, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 91,87 мян Гкал-аар буюу 10,1%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Сүлжээний батлагдсан болон тухайн үеийн зохицуулсан горим ажиллагааг үндэслэн бодсон системийн дулааны ачааллын тооцоогоор 1003,034 мян Гкал дулаан түгээхээр ДҮТ-ийн горим өгөгдсөн.

ДЦС-уудын 1-р сард түгээсэн дулаан: [мян Гкал]

Системийн дулаан түгээлтэнд ДЦС-уудын эзэлсэн хувь



биелэлт 109,6% байна.

ДЦС-ууд	ҮСТ [Гкал]	Дулаан түгээлт	ҮСТ-ний биелэлт	Шалтгаан
ДЦС-2 ХК	29320	33108	112,9%	Энэ сард Улаанбаатар хотын цаг агаар дундажаар -23.0 градус байсан нь ноднингийн мөн үеийнхээс 3.2 градус, олон жилийн дундажаас 1.2 градус илүү хүйтэрсэн байна. Цаг агаарын энэ хүйтрэлт нь дулааны хэрэглээг эрс нэмэгдүүлж хоног тутмын оновчилсон горимоор сүлжээнд чанарын тохируулга хийж ажилласан. Энэ нь дулаан түгээлт төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдэх үндсэн шалтгаан болсон.
ДЦС-3 ХК	296560	337397	113,8%	
ДЦС-4 ХК	429515	462547	107,7%	
ДДЦС ХК	74400	74400	100,0%	Энэ сард ДДЦС-ын дулааны тоолуурт СХЗГ-аас тоолуурын магадлан тогтоох баталгаажуулалт хийж “Улсын баталгаажуулалт хийгдсэн СТД дулааны тоолуурыг зогсоож өгөгдлийг өөрчилсөн нь Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалтын дагуу уг тоолуур нь баталгаагүй хэмжүүр болж байгаа тул 2009.12.30-наас 2010.01.27-ны хоорондох дулааны төлбөр тооцоог дээрх тоолуурын заалтаар хийх боломжгүй” гэсэн дүгнэлт үйлджээ. Иймд станц, сүлжээ зөвшилцөн Хэмжилзүйн байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэн анхны төлөвлөгөөгөөр түгээлтийг тооцоохоор тохирсон. Дарханд энэ сард -25.5 градус хүйтэн байсан нь ноднингийн мөн үеийнхээс 3.3 градусаар илүү хүйтэрсэн байна.
ЭДЦС ХК	78722	88459,5	112,4%	- Эрдэнэт хотод энэ сард онцгой хүйтэрч цаг агаар дундажаар -21.1 градус болсон. Ноднингийн 1-р сартай харьцуулбал 5.7 градусаар, ОЖД-аас 4.3 градусаар илүү хүйтэрч дулаан түгээлтийг нэмэгдүүлжээ. Мөн төлөвлөснөөс 1.7мян Гкал-аар илүү дулааныг уураар түгээсэн.
Систем	908517	995667.5	109,6%	

Горимын хэрэгжилт

Энэ сард дулаан үйлдвэрлэгч болон дамжуулагч ТЗЭ-дийн горимын даалгаврын хэрэгжилтийг “Диспетчерийн графикайн биелэлтийг дүгнэх журам”-ын дагуу тооцоход ДЦС-2-ын сүлжээний буцах усыг өндөржүүлснээр УБДС ХК 0,457 мян.Гкал, ЭДЦС-ын сүлжээний хэсэг 1,96 мян.Гкал-ын дутуу түгээлтийн зөрчлийг тус тус гаргасан. Бусад станц, сүлжээ нь ДҮТ-ийн зохицуулсан төлөвлөгөөг 100,0% хэрэгжүүлж ажиллалаа.

Зургаа. Спот зах зээлийн зохицуулалт

Спот зах зээл дээр нийт 266,1 мян.кВт.ц цахилгаан эрчим хүчийг 5551,2 мян.₮-өөр арилжаалсан байна. Сарын дүнгээр “ДЦС-4”ХК 4360,1 мян.₮, “ЭДЦС”ХК 177,9 мян ₮-ийн тус тус ашигтай, “ДЦС-2”ХК 184,2 мян.₮, “ДЦС-3”ХК 964,4 мян.₮, “ДДЦС”ХК 3389,5 мян.₮-ийн тус тус алдагдалтай ажилласан байна.

- “ДЦС-2” ХК 7,8 мян.кВт.ц цахилгаан эрчим хүчийг 247,7 мян.₮-өөр “ДЦС-4” ХК-аас худалдан авч тус станцад 2,0 мян.кВт.ц цахилгаан эрчим хүчийг 63,5 мян.₮-өөр,
- “ДЦС-3” ХК 60,3 мян.кВт.ц цахилгаан эрчим хүчийг 1127,0 мян.₮-өөр “ДЦС-4” ХК-аас худалдан авч, тус станцад 8,7 мян.кВт.ц ЦЭХ-ийг 162,6 мян.₮-өөр худалдсан,
- “ДЦС-4” ХК 27,3 мян.кВт.ц цахилгаан эрчим хүчийг 595,5 мян.₮-өөр худалдан авч, бусад үйлдвэрлэгчдэд 238,9 мян.кВт.ц цахилгаан эрчим хүчийг 4955,7 мян.₮-өөр тус тус худалдсан байна.
- “ДДЦС” ХК 170,8 мян.кВт.ц ЦЭХ-ийг 3581,0 мян.₮-өөр “ДЦС-4” ХК-аас худалдан авч, тус станцад 9,1 мян.кВт.цагийг 191,5 мян.₮-өөр худалдсан байна.
- “ЭДЦС” ХК нь спот зах зээл дээрээс ЦЭХ худалдаж аваагүй ба “ДЦС-4” ХК-д 7,4 мян.кВт.ц цахилгаан эрчим хүчийг 177,9 мян.₮-өөр худалдсан байна.

1-р сард гарсан спот арилжааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 160,8 мян.кВт.ц буюу 37,7%-аар буурсан байна.

1 дүгээр сар		ДЦС 2	ДЦС 3	ДЦС 4	ДДЦС	ЭДЦС	Худалдсан ЦЭХ-ний нийт дүн	Ашиг, алдагдал, мян төг
ДЦС 2	биетээр, мян кВт.ц		0.000	2.000	0.000	0.000	2.000	
	мөнгөөр, мян төг		0.000	63.500	0.000	0.000	63.500	-184.150
ДЦС 3	биетээр, мян кВт.ц	0.000		8.700	0.000	0.000	8.700	
	мөнгөөр, мян төг	0.000		162.603	0.000	0.000	162.603	-964.404
ДЦС 4	биетээр, мян кВт.ц	7.800	60.300		170.768	0.000	238.868	
	мөнгөөр, мян төг	247.650	1,127.007		3,581.005	0.000	4,955.662	4,360.129
ДДЦС	биетээр, мян кВт.ц	0.000	0.000	9.132		0.000	9.132	
	мөнгөөр, мян төг	0.000	0.000	191.498		0.000	191.498	-3,389.507
ЭДЦС	биетээр, мян кВт.ц	0.000	0.000	7.420	0.000		7.420	
	мөнгөөр, мян төг	0.000	0.000	177.932	0.000		177.932	177.932
импорт	биетээр, мян кВт.ц	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	
	мөнгөөр, мян төг	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	
Худалдан авсан нийт дүн	биетээр, мян кВт.ц	7.800	60.300	27.252	170.768	0.000	266.120	
	мөнгөөр, мян төг	247.650	1,127.007	595.533	3,581.005	0.000	5,551.195	

Долоо. Өрсөлдөөнт зах зээл

Хэрэглээний өсөлт гараагүй учир өрсөлдөөнт зах зээл дээр арилжаа хийгдээгүй байна.

Найм. Импортын хазайлтын секторын урьдчилсан тооцоо

2010 оны 1 дүгээр сард ОХУ-аас импортоор 21 142,6 мян.кВт.ц авч, экспортоор 1 332,2 мян кВт.ц-ийг өгсөн. Импортын эрчим хүчийг 11 142,6 мян.кВт.ц-аар илүү авч, экспорт 567,8 мян. кВт.ц-аар хэмнэж ажилласан.

Импортын графикайн хазайлт СКАДА хяналтын системээр 3 932,4 МВт.ц ба чадлын дундаж 90,96 МВт болсон. 1 дүгээр сард олон жилийн дундажаас илүү хүйтэрсэнтэй холбоотой нүүрсний уурхайн тоноглол бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүйд хүрсэн тул ДЦС-уудад нүүрс нийлүүлэлт багасч нөөц буурсан. Иймээс I/8-I/19 хооронд / I/11, I/12 нд хэвийн горимоор үлдсэн 10 өдөрт нь нүүрс хэмнэлтийн горимд / импортыг төлөвлөснөөс 11 142,6 мян.кВт.ц-аар илүү авч, графикайн хазайлт, сарын чадлын дундаж мөн хэтэрсэн. Импортын графикайн хамгийн их хазайлт I/9-нд 450,18 МВт.ц, хамгийн бага нь I/23 -нд 41,39 МВт.ц байв. ДЦС-4 нь импортын горимыг барьж, бусад ДЦС-уудыг доголдсон үед тохируулж ажилласан.

- ДЦС-4: I/12 нд К-3 доголдож 65,38 МВт.ц, I/24-нд мөн К-3 доголдож 135,2 МВт.ц, I/28-нд импортын горимыг барьж ажиллаагүйгээс 62,88 МВт.ц, I/29 нд К-1 доголдож 66,78 МВт.ц
- ДДЦС: сарын турш нүүрсний чанар мөн дулааны горимоо барихын тулд цахилгааны горим барьж ажиллаагүйгээс 165,7 МВт.ц импортын графикайн хазайлтын зөрчлүүд тус тус гаргасан.

ТЗЭ-ийн импортын графикайн хазайлтад ноогдох хазайлтыг урьдчилан тооцвол:

өдөр	ДЦС-2	ДЦС-3	ДЦС-4	ДДЦС	ЭДЦС	ТБЦДС ба ТК-иуд	Импорт
	МВт.ц	МВт.ц	МВт.ц	МВт.ц	МВт.ц	МВт.ц	МВт.ц
1	1,47	4,96	19,40	3,54	2,83	14,11	46,33
2	2,16	4,10	10,50	3,02	2,55	20,54	42,87
3	1,61	4,69	30,62	1,10	3,00	39,71	80,73
4	1,84	4,64	19,86	7,59	0,83	50,49	85,25
5	1,15	2,60	20,14	8,12	3,95	37,05	73,01
6	7,05	8,84	6,09	8,73	13,13	40,62	84,47
7	2,13	9,31	39,51	9,59	6,80	33,32	100,66
8	3,22	6,14	35,98	10,96	5,32	181,81	243,43
9	3,36	4,79	29,04	27,84	8,45	376,69	450,18
10	3,38	4,79	28,19	19,21	6,28	283,30	345,15
11	3,90	4,97	35,80	69,27	12,46	83,45	209,85
12	2,62	11,63	94,82	17,71	1,38	74,11	202,28
13	3,55	4,27	37,01	4,29	1,79	68,29	119,20
14	1,94	8,57	26,67	6,32	7,74	106,88	158,12
15	1,47	3,41	40,38	5,98	11,80	184,11	247,15
16	1,31	2,95	29,40	3,22	1,56	62,23	100,67
17	1,87	3,47	14,87	2,57	3,23	80,32	106,33
18	1,55	2,80	40,77	0,73	2,80	70,49	119,14
19	2,76	5,43	8,95	5,80	3,68	61,85	88,47
20	1,08	8,09	18,85	10,10	7,80	20,29	66,21
21	0,42	3,58	24,27	2,74	2,13	18,23	51,38
22	1,46	4,50	20,68	4,40	3,80	49,95	84,79
23	0,98	4,00	13,79	3,14	4,18	15,29	41,39
24	1,64	4,94	121,09	2,15	3,21	43,15	176,17
25	2,02	2,88	20,82	3,87	1,48	25,08	56,16
26	1,82	2,05	29,71	7,31	5,23	22,44	68,54
27	1,09	2,67	14,33	6,63	5,36	22,83	52,90
28	4,30	6,44	85,14	3,51	5,22	20,59	125,21
29	1,09	3,21	79,88	2,27	4,83	51,07	142,34
30	1,04	6,00	22,82	4,31	13,39	34,92	82,48
31	0,79	8,00	20,75	5,25	3,63	43,09	81,51
Нийт	66,09	158,70	1040,14	271,28	159,85	2236,30	3932,367

1 дүгээр сарын импортын графикайн хазайлтыг СКАДА хяналт мэдээллийн системийн өгөгдлөөр урьдчилсан байдлаар тооцон гаргасан ба ОХУ-тай байгуулсан гэрээний заалтын дагуу ТЗЭ-дийн гаргасан хазайлт тус бүрийг 20% -г хөнгөлөн тооцсон.

- ДЦС-2: хазайлтын зөрчилд 52,87 МВт.ц

- ДЦС-3: хазайлтын зөрчилд 126,96 мВт.ц
- ДЦС-4: хазайлтын зөрчилд 532,12 мВт.ц
- ДДЦС: хазайлтын зөрчилд 217,02 мВт.ц
- ЭДЦС: хазайлтын зөрчилд 127,88 мВт.ц
- ТБЦДС ба ТК-ууд: хазайлтын зөрчилд 1 789,04 мВт.ц

Ес. Үндсэн тоноглолын зогсолт, ТЗЭ-ийн ажиллагаанд гарсан доголдол

9.1. ДЦС-уудын Зуух, турбогенераторын I сарын засварын зогсолтын бүртгэл:

Станц	Зуух, ТГ	№	Сар, өдөр	Засварт зогссоосон шалтгаан
ДЦС-2	Зуух	5	I/13	Хурц уурын сорьцийн аппарат солих
		5	I/26	Халах гадаргууд гарсан үлээлт устгах
	ТГ	2	I/05	Гол эргүүлэгчийн гэмтэл устгах
ДЦС-3	Зуух	6	I/05	Сүүлийн хэсэг цэвэрлэх, хуяг, лопатка солих
		12	I/15	Утаа сорогч засварлаж тээрмийн шаар солих
		13	I/23	Тоосон системийн гэмтэл устгах
		2	I/24	Тээрмийн хуяг, хүрз солих, сүүлийн хэсэг цэвэрлэх
		3	I/27	Халах гадаргууд гарсан үлээлт устгах
		4	I/29	Галын хотолд гэмтэл устгах
	ТГ	5	I/04	Холхивчуудад үзлэг, засвар хийх
ДЦС-4	Зуух	5	I/09	Халах гадаргууд гарсан үлээлт устгах
		4	I/23	Халах гадаргууд гарсан үлээлт устгах
	ТГ	6	I/07	10,5 кВ-ын таслуур, салгуурын өрөөнд мөс цэвэрлэх
		6	I/16	ПСГ-1-н уур усны алдагдал устгах
		2	I/26	Өдөөлтийн хэлхээний гэмтэл устгах
ДДЦС	Зуух	9	I/12	Халах гадаргууд гарсан үлээлт устгах
		7	I/18	МВ-н доргио устгах
	ТГ	1	I/15	Тосны алдагдал устгахаар
ЭДЦС	Зуух	2	I/16	Халах гадаргууд гэмтэл устгах
		3	I/19	Халах гадаргууд гэмтэл устгах
		5	I/30	Халах гадаргууд гэмтэл устгах
	ТГ	-	-	-

Дээрхи засварын зогсолтыг өвлийн их ачааллыг амжилттай давахын тулд тоноглолыг сэлгэж явуулсны дараа зогсоож засвар, үйлчилгээ хийсэн бөгөөд ТЗЭ-ийн горим ажиллагаанд сөргөөр нөлөөлөөгүй болно.

9.2. Зуух, турбогенераторын I сарын аварийн зогсолтын бүртгэл:

ТЗЭ	Зуух, ТГ	Зуух, ТГ	Сар, өдөр	Аварийн зогсолтын шалтгаан
ДЦС-2	Зуух	3	I/03	Утаа сорогчийн ажлын дугуй гэмтсэн
		4	I/17	Тээрмийн хөдөлгүүрт гэмтэл гарсан
	ТГ	-	-	-
ДЦС-3	Зуух	13	I/04	Экран хагарсан
		11	I/22	Түвшин буух хамгаалалт ажилласан
	ТГ	-	-	-
ДЦС-4	Зуух	3	I/12	ДВ-н хамгаалалтаар зогссон
		3	I/24	Буух хөндийн уур халаагч хагарсан
		8	I/28	Сийрэгжилт буурах хамгаалалтаар зогссон
		1	I/29	ДВ-ын хамгаалалтаар зогссон
	ТГ	3	I/23	Стопорын клапан суусан
		3	I/30	Тохируулгын блок гэмтэл гарч зогссон
ДДЦС	Зуух	8	I/27	ПСУ доголдож авариар зогссон
	ТГ	-	-	-
ЭДЦС	Зуух	-	-	-
	ТГ	-	-	-

ТЗЭ-ийн зуух, турбогенераторын аваарийн зогсолтоос харахад ДЦС-4 ХК-ийн К-3-н халах гадаргууд, ТГ-3-н тохируулгын системд тус тус гэмтэл гарч аваариар зогссонтой холбоотойгоор аваарийн зогсолт нь өнгөрсөн оны мөн үеийнхээс тус бүр нэг нэг зогсолтоор ихэссэн байна.

9.3. Үндсэн тоноглолын нийт зогсолтын судалгаа:

Станц	Үндсэн тоноглол	Аваарийн зогсолт		Гэмтэл устгахаар зогсоосон тоо	Нийт зогсолтын тоо
		2009.I	2010.I		
ДЦС-2	Зуух	2	2	2	4
	Турбогенератор	1	-	1	1
ДЦС-3	Зуух	7	2	6	8
	Турбогенератор	-	-	1	1
ДЦС-4	Зуух	3	4	2	6
	Турбогенератор	1	2	3	5
ДДЦС	Зуух	2	1	2	3
	Турбогенератор	1	-	1	1
ЭДЦС	Зуух	-	-	3	3
	Турбогенератор	-	-	-	-
Нэгдсэн сүлжээний хэмжээгээр		17	11	21	32

9.4. Нэгдсэн сүлжээний 110-220 кВ-ын ЦДАШ, тоноглолын РХА-ийн байгууламжийн 2010 оны 1 дүгээр сарын ажиллагааны мэдээ

№	Дэд станцын нэр	Хамгаалалт ажилласан шугам, тоноглол	Ажилласан хамгаалалт	Өдөр, цаг, мин	ДЗА			Шалтгаан	Тайлбар
1	ДХХБ	Ерөө-110	ГХ-I	02; 09:35	+			Б.з	"С" фаз, 21 км
2	Хар-Айраг	Сайншанд-110	ГХ-II	04; 07:35	+			Б.з	"В" фаз, 77,9 км
3	Булган	Хархорин-Б	ГХ-II	04; 09:22	+			Б.з	"А,С" фаз, 98,9 км
4	ДХХБ	Ерөө-110	ГХ-I	06; 06:16		-		Б.з	"В" фаз, 103 км
5	Сайншанд	Замын-Үүд-110	ГХ-I, МТО	06; 10:10		-		Б.з	Цаг агаар хэвийн
6	Булган	Хархорин-Б	ГХ-II	09; 10:30	+			Б.з	тодорхойгүй
7	Хар-Айраг	Сайншанд-110	ГХ-II	09; 21:20	+			Б.з	"С" фаз, 117 км
8	ДХХБ	Ерөө-110	ГХ-I	10; 12:40	+			Б.з	"С" фаз, 19,1 км
9	ДХХБ	Ерөө-110	ГХ-II	14; 15:09	+			Б.з	"С" фаз, 61,7 км
10	ДХХБ	Ерөө-110	ГХ-II	14; 15:46	+			Б.з	"С" фаз, 55,1 км
11	Булган	Хархорин-Б	ГХ-II	14; 12:07	+			Б.з	"АС" фаз, 126,4 км
12	Булган	Хархорин-Б	ГХ-II	15; 17:33	+			Б.з	"АВ" фаз, 65,4 км
13	ДХХБ	Ерөө-110	ГХ-II	17; 11:04	+			Б.з	"В" фаз, 58,4 км
14	ДХХБ	Ерөө-110	ГХ-I	24; 10:55	+			Б.з	"В" фаз
15	ДХХБ	Ерөө-110	ГХ-I	24; 13:26	+			Б.з	"А" фаз, 101,4 км
16	ДХХБ	Ерөө-110	ГХ-I	26; 14:34	+			Б.з	"В" фаз, 102,4 км

Энэ хугацаанд богино залгааны улмаас РХА-ийн байгууламж нийт 16 удаа ажиллаж таслалт хийгдсэн. АПВ-ын байгууламж 16 ажиллахаас 14 тохиолдолд амжилттай ажиллажээ.

9.5. Бусад

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд хийгдсэн гол ажил:

- I/20-ны 14:00 цагт Туул д/ст-аас 110 кВ-ын Суруга-"А", "Б" шугам болон Суруга-110/35/10 кВ д/ст-ын Тр№1,2-д ачаалал өгсөн.
- I/20-ны 10:50 цагт Мөрөн-110 кВ-ыг таслаж тулгуур №17-18 хоорондох утасны судал тасарсан байсныг хэвийн болгож 11:35 цагт залгасан.
- Цэцэрлэг-110 кВ-ыг I/28-ны 13:59-15:28 цагийн хооронд таслаж тулгуур №97-д утасны судал тасарсныг сэргээсэн.

9.6. ЦТС болон дулаан дамжуулах хувьцаат компаниудад гарсан тасралт, доголдол: УБЦТС ХК-д:

- Салхи шуурганы үеээр 6/10 кВ-ын ЦДШ, тоноглолд гарсан тасралтуудыг цаг тухай бүрд нь шуурхай арга хэмжээ авч хэвийн болгож ажилласан.

ЭБЦТС

- Өвдөгхудаг-35 кВ-д газардлага гарсан тул I/19-ны 07:53 цагт таслаж үзлэг хийхэд тулгуур № 35-д "В" фазын утас тасарсан байсныг засварлаж I/20-ны 03:36 цагт залгасан.

УБДС ХК

- I/06-ны 14:00 эхлэн ДЦС-4-н шууд усны даралт буурч 10,3 ата хүрсэний дагуу үзлэг хийхэд 2-р магистралын ТК-222-н салааны хэрэглэгч болох 15-р хорооллын "ГМ" ОСК-н эзэмшлийн 2-дочг контурын шугамд үлээлт гарсан байсныг 18:10 цагт илрүүлэн хааж гэмтлийг тусгаарлаад уг салааг 22:00 цагт залгав. Үүний улмаас 15-р хорооллын УБ сангийн 8,9,10,11,12,60,61,80,81-р байрууд халаалтгүй болсон ба 2-р контурын гэмтэлийг устгаж 09:48 цагт дүүргээд байруудад 12:30 цагт халаалт өгсөн.

Арав. Хөдөө орон нутгийн үйлдвэрүүдийн горим, ажиллагаа

10.1. ӨДЦС

- К-1,2, ТГ-1, 2 ажилд, Р=1,9/4,15 МВт ачаалалтай хэвийн ажилласан.

10.2. Дорнод бүсийн ЭХС

- До ДЦС нь 3 зуух, 2 ТГ-тай, 9,5 -16,0 МВт цахилгаан ачаалалтай хэвийн ажилласан.
- I/05-ны 22:40 цагт Мардай-110 кВ-ын 181-р тулгуурт "В", "С" фазын хооронд богино залгаа болж реле хамгаалалтаар тасарсан, гэмтлийг устгаж I/06-ны 06:16 цагт залгасан.
- I/11-ны 10:10 цагт Гурванзагал-15 кВ-д газардлага гарсны дагуу таслаж үзэхэд 289-р тулгуурт С фазын утас тасарсан байсныг хэвийн болгож I/12-ны 16:35 цагт залгасан.
- I/20-ний 17:00 цагт Мардай-110 кВ-ын АШ хамгаалалтаар тасарч Баяндун-35, Баянуул-35, Дашбалбар-10, Гурванзагал-10 кВ-ын шугамууд хүчдэлгүй болсон. Үзлэг хийхэд тулгуур №368-д "А" фазын утас тасарсныг залгаад I/21-ний 03:10 цагт залгасан.
- Мардай-110 кВ-ыг I/29-I/31-ний хооронд өдөр бүр 07:17 цагийн хооронд таслаж шугамд үзлэг хийж утас чангарсныг засварласан.

10.3. Баруун бүсийн ЭХС

Баруун бүсийн ачаалал 3,7–13,8 МВт байсан байна.

- I/08 ны 15:06 цагт Мянгад д/ст-д СХТТ-110 кВ хамгаалалтаар тасарсны дагуу үзлэг шалгалт хийлгэн, судлаж үзэхэд зураг төсөлд тусгагдаагүй байсан хүчдэл бууралтын хамгаалалтыг ажилд оруулсан байснаас тасралт гарсан байсан тул ДҮТ-ийн шийдвэрээр уг хамгаалалтыг ажлаас гаргаж СХТТ-110 кВ-ыг I/11 ны 12:00 цагт залгасан.
- I/16-ний 03:15 цагт ОХУ-аас хүчдэл тасарч АПВ-р залгагдах үед Мянгад д/ст-д Дөргөн-110 кВ-ын ЦДШ тасарч, Дөргөний УЦС-д ГГ-1 зогссоныг 03:45 цагт залгасан.
- I/17-ны 17:15 цагт Толбо-35 кВ-д газардлага гарсан тул гараар таслаж үзэхэд 1 фазын утас тасарсныг хэвийн болгож I/19-нд 18:25 цагт ажилд залгав.
- I/19-ны 16:50 цагт Хяргас д/ст-д 10 кВ-ын гүйдлийн тр-ын "С" фазын тулгуур изолятор цууралттай байснаас гэмтэж Хяргас-10 кВ, Зүүнговь-10 кВ-ын шугамууд хүчдэлгүй болсон ба, гэмтлийг засварлаж I/24-ний 09:51 цагт залгасан.
- I/29-ний 04:15 цагт Зүүнхангай-15 кВ газардлагын хамгаалалтаар тасарсны дагуу үзлэг хийхэд 448-р тулгуур дээр утас тасарсныг засварлаж I/30-ний 19:15 цагт ажилд залгасан.

10.4. Дөргөний УЦС

- 1 гидрогенератор ажиллаж, 3 ГГ бэлтгэлд байсан.
- Цахилгаан ачаалал P=1583-3534 кВт.
- Далангийн усны түвшин 1159.33 м
- I/04-ны 06:46, 23:45 цагуудад 2 удаа Мянгад д/ст-д СХТТ-110 кВ хүчдлийн бууралтын хамгаалалтаар тасрах үед ГГ-3 эргэлт ихсэлтийн хамгаалалтаар зогссоныг 07:26, 00:46 цагт ББЭХС-тэй зэрэгцээ ажиллагаанд залгасан.
- I/08 ны 15:06 цагт Мянгад д/ст-д СХТТ-110 кВ зайн хамгаалалтаар тасарсны дагуу үзлэг хийсэн ба хамгаалалт ажилласан шалтгааныг олоогүй тул Дөргөний УЦС-ыг тусд нь гаргасан ба I/11-ны 12:00 цагт ББЭХС-тэй зэрэгцээ ажиллагаанд оруулсан.
- I/14-ны 10:35 цагт Завхан-15 кВ-ын тулгуур № 217,219-н изоляторийн суурь хугарч шугам тасарсныг засварлаж I/15-ны 19:29 цагт залгасан.
- I/16-ны 03:15 цагт Мянгад-110 кВ-ын АШ ихсэх гүйдлийн-I шатаар тасарч ГГ-1 зогссоныг 03:45 цагт синхрон залгав.

10.5. Тайширын УЦС

- 1 гидрогенератор ажиллаж цахилгаан ачаалал P=159-304 кВт, Тайшир, Жаргалан сумын хэрэглэгчдийг ЦЭХ-ээр хэвийн хангаж ажилласан.
- Далангийн усны түвшин 1648.48 м.

Арван нэг. Цаашид анхаарч ажиллах асуудлууд:

Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан мэдээллээр 3 дугаар сар гартал нийт нутгаар хүйтэн, өмнөх жилүүдийн дунджаас их хэмжээний цас орж, цасан шуурга шуурах төлөвтэй байгаа тул:

- Гарч болзошгүй хүндрэл, аварь, саатлаас урьдчилан сэргийлж үндсэн тоноглолын ажиллагааг найдваржуулж бэлтгэлд байгаа тоноглолын бэлэн байдлыг хангах,
- Аваарийн үед ажиллах хүн хүч, сэлбэг материал, техник хэрэгсэлийг хоногийн аль ч цагт саадгүй гаргах талаар зохион байгуулалтын холбогдох арга хэмжээг авч ажиллах,
- ДЦС-дад мазутын 15, нүүрсний 20-оос доошгүй хоногийн нөөцтэй байхаар нүүрс, мазутын нөөцийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарах,
- ЦТС ХК-иудын эзэмшлийн шугам, тоноглолд гэмтэл гарч хэрэглэгчдийн цахилгаан, дулааны эрчим хүчний хангамж тасрах, доголдох үед (ялангуяа Даланзадгад ДЦС-ууд, ДБЭХС, ББЭХС зэрэг ТЗЭ ХК-иуд) энэ тухай мэдээллийг ДҮТ-д цаг тухай бүрд нь шуурхай өгч байхын зэрэгцээ хэрэглэгчдийн ЭХ-ний хангамж 2 цагаас илүү хугацаагаар тасрахаар байвал Орон нутгийн засаг захиргаа, гамшигаас хамгаалах газарт мэдэгдэн хэвийн ажиллагаанд оруулах ажлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж ажиллах,

ЭХДҮТ ХХК 2010-02-05